



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2017 оны 11 дугаар сарын 28

№ 06/89 УДГ-ИАГ/2017/05-ИА Мандалговь хот

**Г Зөрчил арилгуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2, 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар өмнөх оны аудитаар өгсөн “Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх” тухай зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.6 дахь /Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй/ заалтуудыг үндэслэн ШААРДАХ НЬ:

2016 онд хийгдсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах,

Албан шаардлагын биелэлтийг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /С.Сүхбаатар/, нарийн бичгийн дарга /Ж.Мөнгөнцоож/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН:**

АУДИТОР Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ДУНДГОВЬ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

**ЗӨВШӨӨРСӨН:**

С.СҮХБААТАР  
Ц.МОНГӨНЦООЖ

<sup>2</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагадаас тийвсан албан шаардлага, төлборийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зорчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.